



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ ТОГТООЛД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

2009 оны 1 дүгээр сарын 21-ний
өдөр

Улаанбаатар хот

Дугаар 16

Цацрагийн хамгаалалт, аюулгүй байдлын тухай хуулийн 5.3-ыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Засгийн газрын комисс, хороо, үндэсний зөвлөл, ажлын хэсгийн тухай” Засгийн газрын 2005 оны 4 дүгээр сарын 1-ний өдрийн 66 дугаар тогтоолын 1 дүгээр зүйлийн “...16 дугаар” гэсний дараа”, Цөмийн энергийн комиссын бүрэлдэхүүнийг 17 дугаар” гэж нэмсүгэй.

2. Мөн тогтоолын 2 дугаар зүйлийн “17 дугаар” гэснийг “18 дугаар” гэж, мөн тогтоолоор баталсан “17 дугаар хавсралт”-ыг “18 дугаар хавсралт” гэж тус тус өөрчилсүгэй.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Цөмийн энергийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2008 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн 263 дугаар тогтоолын 2 дугаар зүйлийг хүчингүй болсонд тооцсугай.

Монгол Улсын Ерөнхий сайд

Монгол Улсын сайд,

С.БАЯР

Засгийн газрын Хэрэг

эрхлэх газрын дарга

Б.ДОЛГОР